

БАТЛАВ.

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД

*С.Содбаатар* С.СОДБААТАР

444078862 5919497 6579512

## АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭГ ХАРИУЦУУЛАН ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ГЭРЭЭ

2019 оны 22 дугаар  
сарын 01-ны өдөр

Дугаар 73

Улаанбаатар хот

Монгол Улсын Зам, тээврийн хөгжлийн сайдын “Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний жагсаалт батлах тухай” 2016 оны 76 дугаар тушаалыг үндэслэн нэг талаас Зам, тээврийн хөгжлийн яамыг төлөөлөн тус яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд (цаашид “яам” гэх), нөгөө талаас “Автотээврийн Үндэсний Төв” төрийн өмчит үйлдвэрийн газрыг төлөөлөн тус үйлдвэрийн газрын захирал П.Дэлгэрнаран (цаашид “Үйлдвэрийн газар” гэх) нар дор дурдсан нөхцөлөөр харилцан тохиролцож, энэхүү гэрээг байгуулав.

### Нэг. Нийтлэг үндэслэл


1.1. Энэхүү гэрээний зорилго нь Захиргааны ерөнхий хуулийн 52 дугаар зүйлийн 52.1, 52.2.2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 11-д заасан Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудал болон Автотээврийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхээс зарим чиг үүргийг Үйлдвэрийн газраар гэрээний үндсэн дээр шилжүүлэн гүйцэтгүүлэх, түүний хэрэгжилтэд шууд хяналт тавьж ажиллахад оршино.

1.2. Энэхүү гэрээг 2019 оны 02 дүгээр сарын 01-ний өдрөөс 20 19 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хугацаагаар байгуулав.

1.3. Талууд автотээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хуулиар олгогдсон бүрэн эрхийг хүндэтгэх замаар үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

### Хоёр. Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний чиглэл

2.1. Монгол Улсын Зам, тээврийн хөгжлийн сайдын 2016 оны 76 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтад заасан ажил, үйлчилгээг энэхүү гэрээний үндсэн дээр эрхлэн гүйцэтгэнэ.



## Гурав. Яамны хүлээх эрх, үүрэг

### 3.1. Яам нь дараах эрх, үүрэгтэй:

3.1.1 Автотээврийн салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгож, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах;

3.1.2 Автотээврийн салбарын хууль тогтоомж, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд автотээврийн чиглэлээр тусгагдсан бодлого, зорилтот арга хэмжээ болон хуулиар олгогдсон Сайдын эрхлэх асуудлын хүрээний зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг бодлогын удирдамжаар хангаж, мэргэжил арга зүйн болон цаг үеийн шуурхай зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;

3.1.3 Ажил үйлчилгээг хариуцуулан гүйцэтгүүлэх энэхүү гэрээг хэрэгжүүлэх тухай үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангуулах;

3.1.4 Эдийн засаг, нийгмийн хөгжлийн өсөлтийг хангахуйц автотээврийн салбарын хөгжүүлэх бодлого, төлөвлөгөө, төсөл, хөтөлбөр боловсруулах, шинэ техник, технологи туршихад чиглэсэн судалгаа хийхэд хамтран ажиллах, судалгааны тайлан мэдээг хүлээн авах;

3.1.5 Эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого болон автотээврийн салбарыг хөгжүүлэх бодлого, төлөвлөгөө, төсөл, хөтөлбөр боловсруулж, бодлогын удирдамжаар хангаж ажиллах;

3.1.6 Энэхүү гэрээнд заасан ажил, үйлчилгээний талаарх статистик мэдээллийг үйлдвэрийн газраас гаргуулах, ирүүлсэн мэдээллийн үнэн зөв байдлыг хянах;

3.1.7 Автотээврийн чиглэлээр ажил үйлчилгээ гүйцэтгэхэд ашиглагдаж буй мэдээллийн системээс шаардлагатай мэдээллийг авах, хяналт тавих

3.1.8 Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, мэргэшсэн жолоочийн шалгалт авах, үнэмлэх олгох, автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх, авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох, мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх, улс, хот хоорондын болон аймаг, орон нутгийн ачаа, зорчигч, жуулчин, шуудан тээвэрлэлтийг зохион байгуулахад мэргэжил арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;

3.1.9 Тусгай зөвшөөрлийн хүрээнд хийгддэг тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийн төвүүдтэй хийсэн гэрээг дүгнэж, үр дүнг тооцох;

3.1.10 Тээврийн хэрэгслийн болон техникийн хяналтын үзлэгийн гэрчилгээгээр хангах, зарцуулалтад хяналт тавих;

3.1.11 Улс, хот хоорондын тээвэрлэлтийн чиглэлийг тогтоох, өөрчлөх, үйлчилгээний жишиг тарифыг батлах;

3.1.12 Улс хоорондын тээвэрлэлт гүйцэтгэх тээврийн хэрэгсэлд олгох зорчих зөвшөөрлийн бичгийн хэвлүүлэлт, зарцуулалтад хяналт тавих;

3.1.13 Мэргэшсэн жолоочийн шалгалт авах комиссыг томилох, шалгалт авах, үнэмлэх олгох үйл ажиллагаанд хяналт тавих;

3.1.14 Эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн байдалд хяналт, шинжилгээ хийх, үр дүнг тооцож, хэрэгжилтийн байдлыг тодорхой шалгуураар тодорхойлж, үнэлэх;

3.1.15 Гэрээгээр хэрэгжүүлж буй ажил, үйлчилгээний хэрэгжилтэд хяналт тавих, мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангах, гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн тохиолдолд гэрээг хэсэгчлэн болон бүхэлд нь цуцлах, хүчингүй болгох өөрчлөх;

3.1.16 Хуулиар олгогдсон бусад эрх, үүрэг.

### **Дөрөв. Үйлдвэрийн газрын хүлээх эрх үүрэг**

4.1. Үйлдвэрийн газар нь дараах эрх, үүрэгтэй:

Хууль тогтоомж, гэрээ хэлэлцээр, бодлогын баримт бичиг, дээд шатны байгууллагын тушаал, шийдвэрийн хэрэгжилтийг хангах чиглэлээр:

4.1.1 Монгол Улсын холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журам, стандарт болон яамд, эрх бүхий байгууллагуудаас гаргасан тушаал, шийдвэрийн хэрэгжилтийг хангах;

4.1.2 Автотээврийн салбарын хууль тогтоомж, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөө, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд автотээврийн чиглэлээр тусгагдсан бодлого, зорилтот арга хэмжээ болон Сайдын эрхлэх асуудлын хүрээний зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай удирдлага, зохицуулалтыг бүрдүүлэн ажиллах;

4.1.3 Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын Автотээврийн хэлэлцээр, автотээврийн төлөөлөгчдийн ээлжит уулзалтын протоколыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, үр дүнг хагас, бүтэн жилээр тайлагнах;


4.1.4 Засгийн газрын 2018 оны 321 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрөөс автотээврийн салбарт баримтлах бодлого” болон Зам тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 286 дугаар тушаалаар батлагдсан “Төрөөс автотээврийн салбарт баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг улирал тутмын дараа сарын эхний 10 хоногт багтаан яаманд ирүүлэх;

4.1.5 Засгийн газрын 2012 оны 146 дугаар тогтоолоор батлагдсан “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний стратеги” /2012-2020/-г хэрэгжүүлэх төлөвлөгөө болон хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр өөрийн эрхэлсэн ажлын хүрээ, харъяа нутаг, дэвсгэрийн хэмжээнд холбогдох ажлыг зохион байгуулан ажиллах, хэрэгжилтийг 6, 12 дугаар сарын 15-ны дотор багтааж, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах Үндэсний хороонд хүргүүлэх;

4.1.6 Засгийн газрын 2017 оны 98 дугаар тогтоолоор батлагдсан “Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр” болон уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг улирал тутмын сүүлийн сарын 15-ний дотор багтаан яаманд хүргүүлэх;

4.1.7 Эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого болон автотээврийн салбарыг хөгжүүлэх бодлого, төлөвлөгөө, төсөл, хөтөлбөр боловсруулах, шинэ техник, технологи туршихад чиглэсэн судалгаа хийх, холбогдох мэдээллээр хангах;

4.1.8 Орон нутагт автотээврийн ажил үйлчилгээг хариуцан гүйцэтгэхдээ тухайн аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллах, үр дүнг тооцох, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангах;



Хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийг хангах чиглэлээр:

4.1.9. Гэрээгээр гүйцэтгэх ажил, үйлчилгээг хэрэгжүүлэхдээ ТӨБЗГ-аас батлагдсан бүтэц, орон тооны хүрээнд, ажлын байрны тодорхойлолтод заасан шаардлага хангахуйц мэргэжлийн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэх;

4.1.10 Инженер, техникийн ажилтныг бусад оронд сургах, дадлагажуулах, мэргэжилтэн солилцох зэргээр өрсөлдөх чадвар бүхий инженер, техникийн ажилтан бэлтгэх арга хэмжээг зохион байгуулах;

Ачаа, шуудан тээврийн үйл ажиллагааг зохицуулж, зохион байгуулах чиглэлээр:

4.1.11 Олон улсын олон талт болон Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн хүрээнд дамжин өнгөрөх тээвэрлэлтийг зохицуулах, зохион байгуулах бэлтгэл ажлыг хангаж, хэрэгжүүлэх;

4.1.12 Хилийн боомтын татан авалттай нийцүүлэн улс хоорондын тээвэрлэлтийг зохион байгуулах оновчтой хувилбар боловсруулан, хэрэгжүүлэх;

4.1.13 Хилийн боомтын татан авалттай нийцүүлэн улс хоорондын тээвэрлэлт гүйцэтгэх зөвшөөрлийн бичиг олгох ажлыг аж ахуйн нэгжид чирэгдэл багатайгаар ил тод, шуурхай зохион байгуулах;

4.1.14 Тээвэр зохион байгуулалт, зохицуулалтын чиглэлээр уурхай эзэмшигч болон зам хариуцагч аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллах гэрээ байгуулах;

4.1.15 Хот хоорондын ачаа тээврийн үйлчилгээг нэгдсэн зохицуулалтай гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлэх, програм хангамжийг нэвтрүүлэх тээвэрлэгчдийг бүртгэх, үйл ажиллагаанд хяналт тавих;

4.1.16 Ачаа тээврийн нэгдсэн сан бүрдүүлэх чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах, шаардлагатай програм хангамжийг нэвтрүүлэх;


4.1.17 Ачаа тээврийн терминал, логистикийн төв, авто замын дагуух үйлчилгээний барилга байгууламж, автобуудлыг хувийн хэвшлийн оролцоотой барьж байгуулахад дэмжлэг үзүүлэх;

Зорчигч болон жуулчин тээврийн үйл ажиллагааг зохицуулж, зохион байгуулах чиглэлээр:

4.1.18 Олон улсын олон талт болон Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн хүрээнд зорчигч тээвэрлэлтийг зохицуулах, зохион байгуулах бэлтгэл ажлыг хангаж, хэрэгжүүлэх;

4.1.19 Улс, хот хоорондын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгчийг сонгон гэрээ байгуулан батлагдсан тээвэрлэлтийн чиглэл, үйлчилгээний давтамж, цагийн хуваарийн дагуу үйлчилгээг зохион байгуулах;

4.1.20 Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний чиглэлийг шинээр нээх тохиолдолд эдийн засгийн үр өгөөж, тооцоо судалгаа, дүгнэлтийг яаманд хүргүүлж, шийдвэрлүүлэх





4.1.21 Жуулчин тээвэрлэлтийн үйлчилгээг зохион байгуулах, бүртгэл хяналтын тогтолцоог бүрдүүлэх

4.1.22 Улс, хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээг иргэдэд шуурхай, хүртээмжтэй хүргэх, тухайн маршрутын дагуу сум, суурин газар бүрт үйлчилгээг хүргэх, зөвхөн стандартын шаардлага хангаж буй авто замын дагуух үйлчилгээний байгууламжаар дамжуулан үйлчилгээг зохион байгуулах;

4.1.23 Иргэдэд тээврийн үйлчилгээг ойртуулах зорилгоор тээшний хэмжээг тогтоох жин хэмжүүр, тээш хадгалах зориулалтын байрыг бий болгох, тээшний тасалбар олгох, тогтоосон хэмжээнээс илүү гарсан ачааг илгээмжээр хүргэх үйлчилгээний төрлийг бий болгох;

4.1.24 Авто зам болон төмөр замаар гүйцэтгэж буй зорчигч тээврийн үйлчилгээнд тасалбарын нэгдсэн систем бүрдүүлэх талаар судалгаа хийх, санал боловсруулж, шийдвэрлүүлэх;

4.1.25 Нийтийн тээвэр, шуудан тээвэрлэлтийн үйлчилгээг өртөөчлөн гүйцэтгэх туршилтыг хийх, дүгнэлтийг яаманд ирүүлэх;

4.1.26 Автобуудлын барилгыг тухайн жилийн зорилтот түвшинд суулгаж, батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллах;

4.1.27 Нийтийн зорчигч тээврийн осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн тээврийн байгууллагад сахилга хариуцлагыг дээшлүүлэх, тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангуулах;

4.1.28 Тээвэрлэлтэд гарахын өмнө тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал болон жолоочийн хөдөлмөр амралтын дэглэмийг хангуулах, тээвэрлэлтийн үйлчилгээг осол, зөрчил, сааталгүй зохион байгуулах чиглэлээр тодорхой арга хэмжээ авах;

Тээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох үйл ажиллагааг зохион байгуулах чиглэлээр:

4.1.29 Тээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох үйл ажиллагааг зохих журамд заасны дагуу иргэдэд хүртээмжтэй, шуурхай хүргэх, цахим хэлбэрээр зохион байгуулах ажлыг эхлүүлэх;

4.1.30 Автотээврийн хэрэгслийн бүртгэлийг шинэчлэх ажлын хүрээнд сүүлийн 5-аас доошгүй жилийн хугацаанд татвар төлөөгүй, техникийн хяналтын үзлэгт ороогүй автотээврийн хэрэгслийн судалгааг гаргаж, тэдгээрийг бүртгэлээс хасах ажлын төлөвлөгөө боловсруулж, холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах;


4.1.31 Эскпортод гарч байгаа автотээврийн хэрэгслийн хасалтын тодорхойлолтыг нууцлал бүхий үнэт цаас дээр хэвлэн гаргаж өгөх ажлыг хэрэгжүүлэх;

4.1.32 Иргэд импортоор автотээврийн хэрэгсэл оруулж ирэхдээ арлын дугаар /VIN/ нь давхацсан эсэхийг өөрсдөө цахимаар шалгах нөхцөлийг бүрдүүлэх;

4.1.33 Олон улсын Автоинженерүүдийн холбооноос тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээллийг цахимаар авах боломжийн талаар судалгаа хийх;

4.1.34 Зохих хугацаанд улсын бүртгэлд бүртгүүлээгүй, бүртгэлээс хасуулаагүй, техникийн хяналтын үзлэгт хамрагдаагүй тээврийн хэрэгслийг замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх хяналт, хариуцлагын тогтолцоог шинэчлэх;

Ажил, үйлчилгээг хариуцуулан гүйцэтгүүлэх гэрээ - 2019



Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг хийх ажлыг зохион байгуулах чиглэлээр:

4.1.35 Техникийн хяналтын үзлэгийг тус яамтай байгуулсан “Автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх ажил эрхлэх гэрээ”-ний дагуу гүйцэтгэх;

4.1.36 Техникийн хяналтын үзлэгийн дүгнэлтийг цахим хэлбэрээр хэрэглэгчдэд хүргэх үйлчилгээг нэвтрүүлэх;

4.1.37 “Сонгинохайрхан” техникийн хяналтын үзлэгийн төвийг түшиглэн сургалт, дадлагын төв, техникийн сорилт, туршилт, баталгаажуулалтын нэгдсэн лаборатори байгуулах ажлыг эхлүүлэх;

4.1.38 Сүүлийн үеийн автотээврийн хэрэгслийн хийцийн онцлогт тохирсон олон улсын дэвшилтэт техник технологи бүхий тоног төхөөрөмжийн талаар судалгаа хийх;

4.1.39 Автотээврийн хэрэгслийн тоо ихтэй аймаг, сумдын төвд автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх суурин төв байгуулах чиглэлээр судалгаа хийх;

Мэргэшсэн жолоочийн шалгалт авах, үнэмлэх олгох ба авто үйлчилгээнд ангилал тогтоох ажлыг зохион байгуулах чиглэлээр:

4.1.40 Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох ажлыг зохих журамд заасны дагуу зохион байгуулах;

4.1.41 Мэргэшсэн жолоочийн шалгалт авах, үнэмлэх олгох үйл ажиллагааг зохих журамд заасны дагуу зохион байгуулах;

4.1.42 Мэргэшсэн жолоочийн сургалт, шалгалт авах, үнэмлэх олгох үйл ажиллагааг боловсронгуй болгох чиглэлээр холбогдох судалгааг хийж, судалгааны үр дүнгийн талаар санал дүгнэлт боловсруулан яаманд хүргүүлэх


4.1.43 Мэргэшсэн жолоочийн шалгалт авч үнэмлэх олгох үйл ажиллагааны талаарх тайлан мэдээг сар бүр гаргаж, үр дүнг тооцон, дүгнэлтийг яаманд хүргүүлэх

4.1.44 Мэргэшсэн жолоочийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, ашиглах, мэдээлэл солилцох, мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангах зохицуулалтыг бий болгох;

Тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангах, тээврийн хэрэгслээс үүдэлтэй агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр:

4.1.45 Байгалийн гамшиг, цаг агаарын хүндрэл, халдварт өвчин тархах зэрэг гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн нөлөөгөөр тээврийн үйлчилгээнд учирч болох саатлыг урьдчилан тооцож, бэлэн байдлыг ханган, шуурхай арга хэмжээ авч ажиллах;

4.1.46 Осол саатлаас сэргийлэх зорилгоор хөдөлгөөний удирдлагын ажилтнууд болон тээвэрлэлт гүйцэтгэж буй жолооч нарын хооронд хөдөлгөөний нөхцөл байдлын талаар урьдчилсан анхааруулга, зааварчилгааг тухай бүр аж ахуйн нэгж байгууллагаар нь дамжуулан өгч хэвшүүлэх;



4.1.47 Байршил тогтоох систем (GPS)-ийг тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангах, осол, саатлаас урьдчилан сэргийлэх зорилгоор ашигладаг болох нөхцөлийг бүрдүүлэх;

4.1.48 Хөдөлгөөний удирдлагын тайлан мэдээг сар бүр гарган, яаманд хүргүүлэх

4.1.49 Тээвэрлэлтийн явцад гарч буй зам тээврийн ослын шалтгаан нөхцөлийг тодорхойлж, танилцуулгыг яаманд тухай бүр хүргүүлэх;

4.1.50 Зорчигчийн аюулгүй байдлыг хангах даатгалын иж бүрэн үйлчилгээг нэвтрүүлэх;

4.1.51 Автотээврийн салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээнд баталгаат үйлчилгээний тогтолцоог нэвтрүүлэх;

4.1.52 Шинэ техник технологи нэвтрүүлэх замаар автотээврийн хэрэгслээс ялгарч буй хорт утааг бууруулах чиглэлээр нэмэлт тоног төхөөрөмж болон бусад төрлийн бүтээгдэхүүний туршилт, судалгааны ажил хийх, бусад орны туршлагаас судлах;

4.1.53 Агаар, орчны бохирдлыг бууруулах ажлын хүрээнд байгалийн хий /CNG/ нь Монгол орны цаг агаарын нөхцөл байдалд хэрхэн нийцэж байгаа, цаашид хэрхэн ашиглах талаар судалгааны ажил хийх, санал боловсруулж, шийдвэрлүүлэх;

4.1.54 Ашиглалтаас хасагдсан автомашин, түүний эд ангийг устгах, дахин боловсруулах талаар холбогдох судалгааны ажлыг хийх, санал боловсруулж, шийдвэрлүүлэх;

4.1.55 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.11 дэх заалтын дагуу автотээврийн салбарт гарсан үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний тоон мэдээллийн талаарх судалгааг тогтмол мэдээлж байх;

Автотээврийн хяналтыг хэрэгжүүлэх чиглэлээр:


4.1.56 Автотээврийн ажил үйлчилгээнд тавих төрийн хяналтыг тус яамтай байгуулсан “Автотээврийн хяналтыг хамтран хэрэгжүүлэх” гэрээний дагуу хэрэгжүүлэх, “Нийтлэг журам батлах тухай” Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу дотоодын хяналт шалгалтын журам боловсруулж, мөрдөх;

4.1.57 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдөр ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын баталсан “Автотээврийн хяналтын чиглэлээр 2019 онд хамтран ажиллах төлөвлөгөө”-ний биелэлтийг ханган ажиллах;

Мэдээллийн санг бүрдүүлэх, хөтлөх чиглэлээр:

4.1.58 Засгийн газрын 2012 оны 101 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Цахим засаг” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан автотээврийн үйлчилгээг үе шаттайгаар цахим хэлбэрт шилжүүлэх;

4.1.59 Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлд тусгагдсаны дагуу Замын хөдөлгөөний аюулгүй байдлын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд хамрагдах тээврийн хэрэгслийн гаалийн бүрдүүлэлт, татвар, даатгал, техникийн хяналт, бүртгэл, авто үйлчилгээний, мэдээлэл солилцох, мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангах зохицуулалтыг бүрдүүлэх;



4.1.60 Техникийн хяналтын үзлэг, авто үйлчилгээ, бүртгэлийн үйл ажиллагааны техник, тоног төхөөрөмж, програм хангамжийг "Технологийн шинэчлэл" хийх замаар шинэчлэх

4.1.61 Харъяа салбар, төвүүд болон тээвэрлэгч аж ахуйн нэгжүүдийг тээвэрлэлтийн үйл ажиллагааны програм хангамжийн нэгдсэн сүлжээнд холбох, хяналт тавих;

#### Бусад:

4.1.62 Ажил үйлчилгээг хариуцуулан гүйцэтгүүлэх энэхүү гэрээг хэрэгжүүлэхдээ яамны үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдсан "үйлдвэрийн газар"-ын үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан Төрийн нарийн бичгийн даргаар батлуулж, хэрэгжилтийг хангах;

4.1.63 Гэрээний үндсэн дээр хариуцуулан гүйцэтгэх ажил үйлчилгээг шуурхай зохион байгуулах нөхцөл боломжийг хангуулах зорилгоор бусад холбогдох эрх зүйн акттай уялдуулж шаардлагатай дүрэм, журам, стандартыг шинээр боловсруулах, шинэчлэн сайжруулах чиглэлээр санал хүсэлт гаргах, холбогдох дээд шатны байгууллагаар шийдвэрлүүлэх;

4.1.64 Гэрээний үндсэн дээр хэрэгжүүлж буй чиг үүрэг, эрхийг бусад этгээдэд шилжүүлэхийг хориглох бөгөөд мэргэжлийн төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллагатай хамтран ажиллах замаар хэрэгжүүлж болно.

### **Тав. Талуудын хүлээх хариуцлага**

5.1. Талууд энэхүү гэрээ болон Монгол Улсын хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

### **Зургаа. Маргаан шийдвэрлэх тухай**

6.1. Энэхүү гэрээтэй холбоотой аливаа маргаан гарсан тохиолдолд талууд хэлэлцээрийн зарчмаар тохиролцоонд хүрэхийг эрмэлзэнэ.

6.2. Дээрх заалтад заасны дагуу тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд Монгол Улсын хуулийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

### **Долоо. Бусад зүйл**

7.1. Гэрээг 2 хувь үйлдэж, талууд тус бүр нэг хувийг хадгална.

7.2. Гэрээнд шаардлагатай тохиолдолд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

7.3. Гэрээний нэмэлт, өөрчлөлтийг тухай бүрт нь бичгээр үйлдэн Төрийн нарийн бичгийн дарга, Үйлдвэрийн газрын захирал нар гарын үсэг зурж, гэрээний эх хувьд хавсаргана.

7.4. Гэрээний аль нэг зүйл, заалт хүчингүй болсон нь гэрээний бусад зүйл, заалтыг биелүүлэхэд саад болохгүй.



7.5. Үйлдвэрийн газар нь гэрээний биелэлтийг хагас, бүтэн жилээр гаргаж тайлагнах бөгөөд дараа оны гэрээ байгуулахаас өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлсэн талаар яам дүгнэлт гаргаж, гэрээг сунгах эсэх асуудлыг шийдвэрлэнэ.


ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



С.БАТБОЛД

“АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ”  
ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ



П.ДЭЛГЭРНАРАН

ХЯНАСАН:

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ  
ТЗУГ-ЫН ХУУЛИЙН ХЭЛТСИЙН  
АВТОТЭЭВРИЙН САЛБАР ХАРИУЦСАН  
ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН

Г.ОЧХҮҮ

ХЯНАСАН:

“АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ”  
ТӨҮГ-ЫН ЗСХНХ-ИЙН  
ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН

Д.ЭНХБАТ

